



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2026 оны 05 сарын 11 өдөр

Дугаар АБ/18

Булган сум

Даян аварга С.Цэрэн,
Дархан аварга Б.Түвдэндорж аваргын үр хүүхдүүд,
төрөл төрөгсдөд хүндэтгэл үзүүлэх тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.21 дэх заалт, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны IV хуралдааны аймгийн Засаг даргын 2024-2028 оны үйл ажиллагааны “Булганы сэргэлт хөтөлбөрийг батлах тухай” IV/25 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.“Таван аваргын нэрэмжит” улс, аймгийн цолтой 128 бөхийн барилдааныг тохиолдуулан Булган аймгийн Сайхан сумын харьяат, Үндэсний бөхийн даян аварга Сэрээтэрийн Цэрэн, Хангал сумын харьяат, Үндэсний бөхийн дархан аварга Бадамдоригийн Түвдэндорж аваргын үр хүүхдүүд, төрөл төрөгсдөд тус тус 10,000,000 (арван сая), нийт 20,000,000 (хорин сая) төгрөгийн хүндэтгэл үзүүлсүгэй.

2.Хүндэтгэл үзүүлэхэд шаардагдах хөрөнгийг Аймгийн Засаг даргын тамгын газрын нэмэлт санхүүжилтийн дансанд төвлөрсөн Булган аймаг, “Эрдэнэт үйлдвэр” Төрийн өмчит үйлдвэрийн газрын 2026 онд хамтран ажиллах төлөвлөгөөний зардлаас санхүүжүүлэхийг Аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Д.Эрдэнэбилэг)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА

Д.ПҮРЭВ-ОЧИР

